# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2002 оны 07 сарын 22 өдөр                Дугаар 214                Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2000-2001 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголбаяр овогтой Мөнхбаярыг 2002-2003 оны хичээлийн жилээс Англи улсын Холборн коллежийн магистрантурт хууль зүйн чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Гэгээрлийн сайдын 2000 оны 162 дугаар тушаалын хавсралтын 14-ийг хүчингүй болгосугай.

САЙД                А.ЦАНЖИД

2002 7 22 ... бүртгэлийн № 267

990097 3